

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2022 он

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
	8	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02	19.1.9. Төрийн захиргааны төв байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендэрийн үндэсний хороонд дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх.	<p>1. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Хүйсийн 60:40 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах” тухай заалтыг Үндэсний геологийн алба нь эрэгтэй албан хаагч 14, эмэгтэй албан хаагч 18 буюу 58:42 гэсэн хүйсийн харьцаатай ажиллаж байна.</p> <p>2. Жендэрийн үндэсний хороо болон Жендэрийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан хүйсийн тэнцвэртэй байдлын дэлгэрэнгүй судалгааг заасан цаг хугацаанд гаргаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнд 2022 оны 01 дүгээр сарын 13-нд болон, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагч н.Туяацэцэгт цахим хэлбэрээр хүргүүлсэн.</p> <p>3. 2022 оны хагас жилийн тайлан мэдээллийг Уул уурхай, хүнд</p>	100%		Үндэсний геологийн алба

				<p>үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэв.</p> <p>4. Мерит төслөөс зохион байгуулдаг "Эмэгтэйчүүдийн манлайлал" цуврал уулзалтуудад байгууллагын төлөөллүүдийг оролцуулж хэвшсэн.</p>			
11	16	<p>Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01</p>	<p>55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Үндэсний геологийн албаны Сургалтын төлөвлөгөөнд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд Хувь хүний хөгжил, манлайлал, мэргэжлийн, Удирдлагын академийн мэргэшүүлэх зэрэг чиглэлээр 9 сургалтыг тусгаж, 2022 оны хагас жилийн байдлаар 9 сургалтад давхардсан тоогоор 36 албан хаагч хамрагдсан. Үүнд:</p> <p><i>Танхимаар:</i></p> <ul style="list-style-type: none"> - Архивын ерөнхий газрын төлөвлөгөөт мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагч хамрагдсан. - 2022 оны 06 дугаар сарын 15-17-нд Мэдээллийн аюулгүй байдлын сургалтад 1 албан хаагч хамрагдана. <p><i>Цахимаар:</i></p> <ul style="list-style-type: none"> - Мерит төслийн ёс зүйн сургалтад 01 дүгээр сарын 28-ны өдөр цахимаар зохион байгуулж, нийт 22 албан хаагч оролцов. - Төрийн албаны зөвлөлийн Төрийн байгууллагын бүтээмж" Төрийн албаны шинэтгэлийн эхлэл, Бүтээлчээр хурдан уншихуй, Монгол орны хөгжлийн хэтийн төлөв 	100%		<p>Үндэсний геологийн алба</p>

				<p>- Авилгатай тэмцэх газрын Авлигын эсрэг давтан цахим сургалтад 5 албан хаагч хамрагдав.</p> <p><i>Төрийн албаны сургуулийн</i></p> <p>1.Ахлах түшмэлийн багц сургалтад 1 албан хаагч, 2.Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт – 1 албан хаагч, хичээл нөхөлт 3.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт – 1 албан хаагч тус тус суралцсан.</p> <p>Ийнхүү Үндэсний геологийн алба Сургалтын хөтөлбөр, Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдийг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэн ажиллав.</p>			
76	114	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2022-05-11 Дугаар 2022_195	2. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Монгол Улсын хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтад тусламж үзүүлэх тухай төсөл хэрэгжүүлэх гэрээ”-ний дагуу Дорноговь аймаг дахь хилийн Замын-Үүд боомтын өргөтгөл,	Дорноговь аймаг дахь хилийн Замын-Үүд боомтын өргөтгөл, шинэчлэлийн авто зам, талбайн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Дорноговь аймгийн Засаг дарга, Өмнөговь аймгийн Засаг дарга нарт даалгасны дагуу олгодог байна.	-		ГБГ Үндэсний геологийн алба

		<p>шинэчлэлийн авто зам, талбайн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг 1 дүгээр хавсралт, Өмнөговь аймаг дахь хилийн Гашуунсухайт боомтын өргөтгөл, шинэчлэлийн авто зам, талбайн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, Өмнөговь</p>				
--	--	---	--	--	--	--

			аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай.			
77	116	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн	Үндэсний геологийн алба Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор доорх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон тул Үндэсний геологийн албаны дэд даргыг ажлаас чөлөөлсөн. 1.2. Үндэсний геологийн албаны төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлсэн. 1.3. Албаны үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт,	100%	Үндэсний геологийн алба

		<p>этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын</p>	<p>семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулсан.</p> <p>1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулаагүй, төсвөөс хөрөнгө зарцуулаагүй ажиллав.</p> <p>Хуулийн 15.2.4. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэн ажиллав.</p> <p>Мөн Үндэсний геологийн албаны Геологийн баримтын төв архивын үйл ажиллагааг цахимжуулах зэрэг Албаны “Стратеги төлөвлөгөө 2020-2024”-д тусгагдсан зорилт арга хэмжээнүүдийг хэмнэлтийн горимд шилжүүлэн, хориглож ажиллаж байна.</p>			
--	--	--	--	--	--	--

			төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.			
78	118	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан	Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан Үндэсний геологийн албаны албан хэрэгцээнд ашиглагдаж байсан, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, хэрэглээг хязгаарласан болно.	100%	Үндэсний геологийн алба

			төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.				
Засгийн газрын тэмдэглэл							
	122	2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2018-07-04 Дугаар 2018_29	XX.4. 2. . Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлох, улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг судлах, байгалийн өнгөт чулууны жишиг үнэлгээг тогтоолгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт;	Монгол оронд өнгөт, эрдэнийн чулууны геологийн судалгаа шинжилгээ 1960-аад оноос хийгдэж ирсэн ч тухайлсан сэдэвчилсэн судалгаа хийгдэж байгаагүй. Иймээс “Монгол орны өнгөт, эрдэнийн чулууны орд, илэрлүүдийн тархалт, байршлын зүй тогтол, хэтийн төлөвийн үнэлгээ” геологийн судалгааны төслийн Улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх шаардлагатай бөгөөд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд тусган ажиллахаар төлөвлөж байна. Цаашид Өнгөт чулууг олборлох, худалдах, худалдан авах, тээвэрлэхтэй холбоотой журмын төслийг	50%		Үндэсний геологийн алба

				боловсруулах, судалгааны ажлын үр дүнд үндэслэн Монгол улсын засгийн газрын 2001 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 54 дүгээр тогоолоор батласан “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалт” журмын жагсаалтанд оруулах эсэх асуудлаар судалгааны ажлыг эхлүүлсэн.			
	134	2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 74 дугаар тэмдэглэл 2020-12-30 Дугаар 2020_74	XXIX.7. . “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн эзэмшдэг “Овоот хяр” нэртэй ХҮ-21670 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай дахь “Хойд бүргэд” нэртэй алтны үндсэн ордод “Геологийн судалгааны төв” ТӨҮГ болон “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн хамтран гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажлын үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Хойд бүргэд” нэртэй алтны үндсэн ордын нарийвчилсан	Ашигт малтмалын мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан газар хариуцна.	-		ГБГ АМГТГ Үндэсний геологийн алба

			хайгуулын ажлыг дуусгах, уг тусгай зөвшөөрөл бүхий талбайд илэрсэн алт, алт-зэсний илрэлүүдэд нөөц тогтоох эрэл, хайгуулын нэмэлт ажилд шаардагдах эх үүсвэрийн асуудлыг судлан саналаа боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгав.			
109	163	2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр 56 дугаар тэмдэглэл 2021-10-20 Дугаар 2021_56	ҮИИ.8. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх геологи, судалгааны төслүүдийн ажлын гүйцэтгэл 2022 оны эхний 5 сарын байдлаар 4,661.2 сая төгрөг байна.	100%	ГБГ Үндэсний геологийн алба

			геологи, судалгааны ажлын явц, эрдэс баялгийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав.			
124		2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12	Х.5. . 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв	2022 онд Үндэсний геологийн албанд 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл гомдлын сайтад Төслийн санхүүжилт олгохгүй байгаа тухай 2 гомдол ирснийг шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлт 100%.	100%	Үндэсний геологийн алба

			болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.			
133	224	2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24	XIY.11.2. Авто замын барилгын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах нэмэлт талбайн солбицлыг батлуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар	Авто замын барилгын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах нэмэлт талбайн солбицлыг батлуулах асуудлыг тухайн аймгийн Засаг дарга нь хариуцан батлуулдаг байна.	-	Үндэсний геологийн алба

			шийдвэрлүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав;				
Дундаж					92,85%		

2022 оны 12 дугаар сарын 10-ны өдөр.